



**ЗАВХАН АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2023 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/19

Улиастай

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, үйл ажиллагааны чиглэл өөрчлөх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.17, 19.18, Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 06-р сарын 23-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/400 дугаар тушаал, 2022 оны 9-р сарын 27-ний өдрийн “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” А/480 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 30-ний өдрийн Б/54 дүгээр захирамж, Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2023 оны 06 дугаар сарын 02-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах байгууллагуудыг нэгдүгээр, тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны чиглэл өөрчилсөн байгууллагын нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэлтэс (Ө.Уранчимэг)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Ж.Должинсүрэн)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



М.ҮРЖИНХАНД

202306000135

Эрүүл мэндийн газрын даргыноны. 06
дугаар сарын 02. өдрийн 1119 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААГ СУНГАХ БАЙГУУЛЛАГА

№	Байгууллагын нэр	Тусгай зөвшөөрлийн сунгасан хугацаа	Тусгай зөвшөөрлийн эхлэх огноо	Тусгай зөвшөөрлийн дуусах огноо
1	Улиастай сумын “Ариусгал Завхан” ххк ахуйн шавж мэрэгч устгах, халдваргүйжүүлэх үйлчилгээ	5 жил	2023.05.17	2028.05.17
2	Улиастай сумын Үе залгамжлагч үүдэн эмнэлэг	5 жил	2023.06.13	2028.06.13
3	Алдархаан сум “Тунамал бүрд” ххк-ний эмийн сан	5 жил	2023.06.27	2028.06.27
4	Завхан эм хангамж ХХК-ний эмийн сан	5 жил	2023.06.02	2028.06.02
5	Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлэг	5 жил	2023.06.26	2028.06.26

--oOo--

Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 06
дугаар сарын 02 өдрийн 1/19 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛИЙГ ӨӨРЧИЛЖ,
ГЭРЧИЛГЭЭГ ШИНЭЧЛЭН ОЛГОХ БАЙГУУЛЛАГА**

№	Байгууллагын нэр	Одоогийн үйл ажиллагааны чиглэл	Өөрчилсөн үйл ажиллагааны чиглэл	Өөрчилсөн огноо
1	Улиастай сумын "Үе залгамжлагч-Элит сувилал"	Сувлал, нөхөн сэргээх	Сэргээн засах сувилал	2023.06.02

--oOo--